



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 23 өдөр

Дугаар А/40

Арвайхээр сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.3, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/301, А/265 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Рашааныг зохистой ашиглах, хамгаалах журам”, Эрүүл мэндийн сайд, барилга хот байгуулалтын сайдын 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/149/78 дугаар тушаалаар батлагдсан “Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн сүлжээнд эрсдэлийн үнэлгээ хийх заавар”, Өвөрхангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 4.1.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд хүн амын ундны усны чанар, аюулгүй байдлыг хангах, төлөвлөгөөг боловсруулж, батлуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Хүн амын ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахыг ажлын хэсэг (И.Доржсүрэн)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А. ИШДОРЖ

6223 11 0094

Аймгийн Засаг даргын 2023 оны
01 дүгээр сарын 15-ны өдрийн
А/НО дугаар захирамжийн
хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга: И.Доржсүрэн (аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд: Г.Баясгалан (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)

С.Дуламрагчаа (Онги-Таац голын сав газрын захиргааны дарга)

Г.Ганбаатар (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Онцгой байдлын газрын Төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч)

Ч.Бат-Өлзий (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн)

Н.Хишигт (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

Г.Цэвэлмаа (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газар зохион байгуулалт төлөвлөлт, газар өмчлөлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)

М.Ганцэцэг (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Эрүүл мэндийн газрын Орчны эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн)

Ц.Эрхномуун (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Эрүүл мэндийн газрын Халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн)

Ш.Оюунбилэг (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн Байгаль орчны итгэмжлэгдсэн лабораторийн эрхлэгч)

С.Оюунмандал (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Стандарт, хэмжил зүйн хэлтсийн итгэмжлэгдсэн лабораторийн шинжээч, нян судлал)

Я.Лхам (Онги-Таац голын сав газрын захиргааны Усны чанар, экологи, төлбөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Б.Даваадагва (Онги-ус суваг" ОНӨААТҮГ-ын ерөнхий инженер)

Сумын Засаг дарга нар

Сумын Байгаль орчны улсын байцаагч нар

Нарийн бичгийн дарга: Б.Энхсүрэн (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Байгаль орчин аялал, жуулчлалын газрын Усны нөөцийн ашиглалт, хамгаалалт хариуцсан мэргэжилтэн)